



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/546

Номгон

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Өлзийт сумын нутаг “Улаан дэлийн сайр” хэмээх 395.9 гектар талбайд “Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл”-ийг 3 жилийн хугацаатайгаар “Жантөрин” ХХК-д олгосугай.

2.Хууль, тогтоомжийн дагуу хайгуулын ажлын төлөвлөгөө, холбогдох баримт бичгийг мэргэжлийн байгууллагуудаар хянуулж, хариуцлагатай ажиллахыг захирал Б.Лхагвасүрэнд үүрэг болгосугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлүүлж, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

4.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дээрх аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Өлзийт сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат), хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон талбайг зураг зүйн мэдээллийн санд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН